



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/398

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу "Оч манлай" ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг Тэмүүжингийн гудамжид байрлах, Худалдаа үйлчилгээний зориулалттай 2544 м² газрыг иргэн Даваадоржийн Ариунболдод 56 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Даваадоржийн Ариунболдын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.


4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Д.Ариунболдод үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/134 дүгээр захирамжийн хавсралтын 2, 4, 5 дугаар хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны 11 сарын
27 өдрийн 4 дүгээр захирамжийн хавсралт
1398



**ХЭРЛЭН СУМАНД ГАЗАР ЭЗЭМШИЖ БАЙГАА
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ**

2018.10.22

Чингис хот

д/д	Иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ /м ² /	Байршил	Газар эзэмшлийн зориулалт	Хугацаа /жил/
1	Даваадоржийн Ариунболд	СЮ70060971		724	Хэрлэн сум, 1-р баг, Тэмүүжингийн гудамж,	Худалдаа, үйлчилгээ	56
2	Даваадоржийн Ариунболд	СЮ70060971		890	Хэрлэн сум, 1-р баг, Тэмүүжингийн гудамж,	Худалдаа, үйлчилгээ	56
3	Даваадоржийн Ариунболд	СЮ70060971		930	Хэрлэн сум, 1-р баг, Тэмүүжингийн гудамж,	Худалдаа, үйлчилгээ	56